

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 08 сарын 21 өдөр

№ R-2024-38

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцлийг батламжлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны ТУЗ 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаараа дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) нь 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаараа гаргасан шийдвэрийн үр дүнд, Банкны эрх бүхий албан тушаалтнууд, эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд болон Банкны хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдэд тус тус олгосон, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий нийт 338,000,000 (гурван зуун гучин найман сая) төгрөгийн үнийн дүнтэй 5 зээл (“Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл”)-ийг батламжлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг;
- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй ердийн нөхцөлөөс давуу тал олгоогүй болохыг ЭУХ тодорхойлсон болохыг; мөн
- ТУЗ нь ЭУХ-оос санал болгосны дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг батламжлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хавсралт ёсоор батламжилсугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 08 сарын 21 өдөр

№ R-2024-39

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцлийг батламжлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны ТУЗ 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаараа дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) нь 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаараа гаргасан шийдвэрийн үр дүнд, Банкны эрх бүхий албан тушаалтанд олгосон, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий нийт 200,000,000.00 (хоёр зуун сая) төгрөгийн үнийн дүнтэй зээл (“Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл”)-ийг батламжлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг;
- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь Ажилтны зээлийн ерөнхий журамд нийцсэн болохыг ЭУХ тодорхойлсныг; мөн
- ТУЗ нь ЭУХ-оос санал болгосны дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хавсралт ёсоор батламжилсугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ